

ЦЭРГИЙН СУРГАЛТЫН ТУХАЙ ТҮҮХЭН СУРГАМЖ, ӨНӨӨГИЙН ОЙЛГОЛТ

Ч.Баттулга

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын акедимийн 8012 дугаар дамжааны суралцагч, Магистрант, хошууч

Товч агуулга: Цэргийн сургалт нь нийтийн тооллын өмнөх үе, Их Монгол Улсын, Ардын хувьсгалын үеийн сургалт, өнөөгийн цэргийн сургалтын зарчмууд, түүнийг тактикийн бэлтгэл сургуулийн явцад тусгах, сургалтын арга хэлбэрийн тухай ойлголт, сургалтын аргын агуулга, зарчим түүнийг тактикийн бэлтгэл сургуулийн явцад хэрхэн тусгахыг зорилоо.

Abstract: Military training is the period before the census, training during the Great Mongolia and People's Revolution, the principles of current military training, how to reflect it during the tactical training school, the concept of training methods, the content and principles of the training method, how to reflect it during the tactical training school aimed.

Түлхүүр үгс: Цэргийн сургалт, түүхэн уламжлал, арга хэлбэр, тогтолцоо, тактик-жагсаал, лекц, материал.

Keywords: Military training, historical traditions, methods, systems, demonstrations, lectures, materials.

Оршил. Нэр томъёоны хэрэглээ:

ЦЭРГИЙН СУРГАЛТЫН ОНОЛ;

Цэргийн сургалтын тухай онол нь сургалтын үйл явцын хамгийн нийтлэг зүй тогтоол, армийн нийт бүрэлдэхүүнийг бэлтгэх зорилт, агуулгыг шинжлэн судалж үүний үндсэн дээр сургалтын зарчим, арга хэлбэрийг боловсруулдаг юм.

ЦЭРГИЙН СУРГАЛТ;

Дайчдад практик ажиллагаанд нь зайлшгүй шаардлагатай цэргийн хэргийн мэдлэг, чадвар, дадлага эзэмшүүлэх, цэргийн хамт олон

/салбар, анги, нэгтгэл/-ыг байлдааны ажиллагаа явуулахад бэлтгэх, гар нийлэмжийг хангахад чиглэгдсэн зохион байгуулалт, зорилго чиглэл бүхий үйл явц юм.

- Цэргийн сургалтын үндсэн зарчмууд нь:

Шинжлэх ухаанч, цэргийг дайнд хэрэгтэй бүхэнд сургах шаардлага, суралцагсдын идэвхитэй, ухамсартай байдал:

- Үзүүлэнт байдал
- Системт байдал
- Дэс дараат байдал

- Суралцагсдад ойлгомжтой байх
- Гүн бат мэдлэг, чадвар дадлагатай байх

Сургалтад хамт олон ба нэг бүрчлэн /ганцаарчилсан/ хандлагыг зөв хослуулах зэрэг болно.

Цэргийн сургалт нь бие бүрэлдэхүүний авъяас, бүтээлч санаачилгаа дээд зэргээр илрүүлэн гаргах таатай нөхцөл бүрдсэн тохиолдолд амжилтад хүрнэ. Мөн захирагч, дарга нар нь цэрэг нэг бүрийн оюун ухаан, бие бялдрын бүх боломж, түүний сэтгэлзүйн хөгжлийн түвшин /хүртэхүй, сэтгэлгээ, ой, хэл яриа/ ба сэтгэлзүйн шинж чанар /зан ааш, авир араншин, авъяас/-ыг бүх талаар харгалзан тооцож чаддаг болсноор амжилт гаргана.

Нэг.Түүхэн уламжлал

а/Хүннү гүрний үе;

Хүннүгийн хүн амын тоо Хан улсын нэг мужаас ч бага байсан бөгөөд хүннү судлаач ихэнх эрдэмтдийн тооцоолсноор (В.С.Таскин, Л.Н.Гумилев, Ма Чан шоу гэх зэрэг) Модунь шаньюйн үед Хүннүгийн хүн амын тоо 1 сая 500 мянга орчим байсан. Хятадын түүхэн сурвалж болох “Ши цзи” буюу “Түүхэн тэмдэглэл”-д “Байдан ууланд Хан улсын Гаодигийн цэргийг бүслэхэд Модунь 400 мянган цэрэгтэй байсан” гэсэн бол мөн хятадын эртний түүхэн сурвалж болох “Хан шу” буюу “Хан улсын бичиг”-т 300 мянган цэрэгтэй байсан гэжээ.

Хан улсын түүхч Цзя И-гийн (НТӨ 200-168 он) мэдээгээр 5 хүнд нэг цэрэг оногдож байсан байна.

Хүннү улс төр цэргийн нэгдсэн зохион байгуулалттай байсан учир улс орны амьдралд цэрэг онцгой үүрэг гүйцэтгэж байв. Модун шаньюй олон овог аймгийг нэгтгэх, хөрш зэргэлдээх олон улс орныг эзлэхэд хүннү цэрэг гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Тэрээр “Цэрэг бол төр, улсын гол хэрэгсэл” хэмээн үзэж улсдаа цэргийн шинэчлэл хийж, цэргүүдийг нэгэн удирдлага дор нэгтгэж, маш хатуу чанд сахилга баттай болгож чадсанаараа хүчирхэг байжээ.

Хятад сурвалжид өгүүлснээр хүннү нар хятадуудтай тулалдахдаа давхилт дундаа алсын зайнаас харвахыг илүүд үздэг байсан ба тэд энэ эрдмийг бүр багаас эзэмшдэг агаад нас биед хүрэх үедээ харвах намнах чадвараар гойд сайн болсон байдаг байв. Энэ тухай “Ши цзи” буюу “Түүхэн тэмдэглэл”-д “Хүүхэд дөнгөж хонь унаж чадах болмогцоо хулгана, зурам харвах ба нэлээд өсч ирэхлээрээ үнэг, туулай харваж иднэ. Нум хэрэглэж чадах хүн болгон цэрэг болно” гэсэн байна.

Хүннү “Намар адуу мал таргалах үеэр бүх хүмүүс ой модыг самнан ан хийдэг” байсан ба энэ мэт зохион байгуулалттай ав хомрог нь нэг ёсны цэргийн сургууль болдог байв. Нум сум бол хүннүгийн байлдааны болоод ангийн гол зэвсэг байсан бөгөөд Хүннү-Парфяны нум нь НТӨ I зууны сүүлч гэхэд хамгийн шилдэгт тооцогддог байсан.

Хүннү цэрэг нь тус тусын овог аймгийн цэрэг эр бус, улсын цэргийн нэгдсэн аравтын зохион байгуулалттай байсан бөгөөд улсын дэвсгэр нутгийг хятадын түрэмгийлэл зэргээс батлан хамгаалах үүрэгтэй байжээ.

Хүннүгийн эмэгтэйчүүд эрчүүдийн нэгэн адил морь унаж, нум сум харваж чаддаг. “Хожуу Хан улсын бичиг. 79 дүгээр бүлэг”, “Давс төмрийн бодлого. Гавьяа бүлэг” зэрэгт өгүүлснээр “Хүннү эмс охид цэргийн хуарандаа мал сүргээ хариулдаг. Ар талын нүсэр ажлыг дангаар гүйцэтгэдэг. Алсын аян дайны үед эмэгтэйчүүд, хөгшид үхэр, хонь, адуу, луусаа даган нүүдэллэж цэргийг хоол хүнсээр огт үл тасалдуулдаг” байжээ.

Хүннүд их цэрэг, цоохор цэрэг гэж хоёр төрлийн цэрэг байсан ба их цэрэг нь байнгын, цоохор цэрэг нь түр цэрэг байсан. Хүннүгийн түмт, мянгат, зуут, аравтын дарга нар цэргүүдийн байлдааны бэлэн байдлыг бүрэн хариуцдаг байсан.

б/Их Монгол улсын үе буюу XIII зууны үе;

Арван өрхөөс татсан арван цэргээс бүрдэх аравт, арван аравт бүрийн цэрэг нийлсэн зуут, арван зуутын цэргээс бүрдсэн мянгат, арван мянгатын цэрэг бүхий түмт байхаар журамласан цэргийн зохион байгуулалтын тогтолцоо нь Их Монгол улс байнгын хүчирхэг армитай байх нөхцлийг бүрдүүлсэн юм.

Чингис хаан цэргээ шинэ зохион байгуулалтанд оруулж, байнгын армийг бий болгов. Цэргийн

ерөнхийлөн захирах тушаалтныг буй болгож, тэр тушаалд нэрт жанжин Хубилай-г томилов. Мөн дээд хэмжээний арван хоёр зөвлөхөөс бүрдсэн Илдэч хэмээх цэргийн бодлогын газрыг байгуулав. Цэргийн яамны маягийн эл байгууллага нь цэргийн эрдэм ухааныг хөгжүүлэх, цэргээ байлдааны байнгын бэлтгэл сургуультай байлгах, цэргийн жанжин, дарга нарын удирдлагын ур чадварыг ямагт төгөлдөржүүлэх, армийн зохион байгуулалтыг чанд цэгцлэх, дээд зэргийн уян хатан, хөдөлгөөнт армийг байлдааны бэлэн байдалд барьж байх гол үүрэгтэй байжээ.

Их Монгол улс хүчирхэг зэвсэгт хүчинтэй байсан нь цэргийн сургалтын бүхэл бүтэн тогтолцоо бүрдүүлсэнтэй холбоотой. Эл тогтолцоо нь, хүүхдээ хар багаас нь морь унуулж, нум сум харвуулж сургах, байлдах болон агнах наад захын эрдмийг эзэмшүүлэхийг иргэн бүрийн зайлшгүй үүрэг болгосон бүх нийтийн цэргийн бие даасан сургалт; мөн моринд гарамгай болгох, сэлэмдэх урлагт суралцах, оньсон техник эзэмших зэрэг албан ёсны мэргэжлийн сургалт гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байжээ.

Тогтмол тэмцээн, наадам зохион байгуулж байсан нь зугаа цэнгэлийн төдийгүй, цэргийн сургалтын үр дүнг шалгах гол хэлбэр байсан.

Их Монгол улсын зэвсэгт хүчин нь хөнгөн болон хүнд морин цэргээс бүрдэж байв, Хөнгөн морин цэрэг хөдөлгөөнт чанар, суу залиараа нэн гайхамшигтай. Хүнд морин цэрэг нь өвч зэвсэглэсэн тусгай зориулалт бүхий

цэрэг юм. Цэргийн гол зэвсэг нь нум сум, сэлэм, жад, сүх төмөр, шийдэм, бороохой, хуяг дуулга байв. Монголын морьт арми нь хэрэм боомт эвдэх инженерийн ангитай байжээ. Ийм ч учраас монголчууд урьд өмнө дэлхий дахинд хэзээ ч байгаагүй цэрэг дайны номлолыг бий болгосон байдаг.

в/Богд Хаант Монгол Улсын үеийн цэргийн сургалт;

Манжийн нөлөөнд 200 гаруй жил байсан Монголчууд 1911 оны цагаагчин гахай жил хувьсгал хийж өөрсдийн эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээж Богд Хаант Монгол Улсыг сэргээн байгуулсан. Хувьсгалаар олж авсан эрх чөлөө, тусгаар байдлаа батлан хамгаалахын тулд үндэсний цэргийг байгуулах явдал шинэ төрийн нэн чухал зорилт болсон юм. Батлан хамгаалах хүчний байгууллага нь үндэсний уламжлалд суурилахын зэрэгцээ тухайн цагт тэргүүнд тооцогдож байсан европ маягийн орчин үеийн цэргийн тогтолцоог хүлээн авах учиртай байв.

Богд Хаант Монгол улсын батлан хамгаалах төрийн төв байгууллага Цэргийн яамыг 1911.12.29-30-нд Богд эзэн хааны зарлигаар байгуулж үйл ажиллагаа нь эхэлсэн байна.

Халхын Хүрээний Бүгд хэргийг Түр ерөнхийлэн шийтгэх газар (1911 оны зун байгуулсан)-аас Манж Чин улсаас тусгаарлаж, 1911 оны эцсээр Сэцэн хан, Түшээт хан аймагт цэргийн дайчилгаа явуулсан юм. Энэ шийдвэрийн дагуу Их Хүрээний ойролцоо хошуудаас 1000 шахам цэрэг цугларсны дийлэнх нь Түшээт хан аймгийн жанжин Ханддоржийн харьяат

цэрэг байв. Иймээс Хиагтын зүүн, баруун этгээд 47 харуул тутмаас захирах түшмэл 1, цэрэг 9-ийг дайчлан Их Хүрээнд ирүүлсэн байна.

“Монгол цэргийг бэлтгэн сургах тухай” Монгол-Оросын хэлэлцээг 1913.02.03-нд байгуулсан байна. Энэхүү хэлэлцээний дагуу “морьтой цэрэг хоёр хороо, хороо бүрд 6 суман, пулемёт бууны 6 хүн, их үхэр бууны 100 шахам хүн бүгд 1900 хүн” бүхий морьт бригад байгуулахаар хэлэлцэн тохирсон байна. Энэ цэргийг сургахаар цэргийн ноёд 2, түмэд 15, дарга 42-ыг Монголд томилон ирүүлэх, энэ сургах зардал 350 мянган цөлхөөвийг урьд олгосон 2 сая цааснаас суутгахаар хэлэлцэн тохирчээ.

Ийнхүү Нийслэл Хүрээний Хужирбулан хэмээх газар анх удаа европын тогтолцоогоор монгол цэргийг сургаж бэлтгэх болсон нь ихээхэн дэвшил төдийгүй, орчин цагийн боловсронгуй цэрэг байгуулах эхлэл болсон.

г/Ардын хувьсгалын үеийн цэргийн сургалт;

Ардын хувьсгалын цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо нь цэргийн биеийн тамирыг чухалчлан үзэх, цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгох, орчин үеийн зэвсэг, техникийг эзэмшүүлэн сургахад чиглэгддэг байсан ба “Даргын сургууль”-ийг төгсөгчдөөс сургагч нарыг томилон сургадаг байсан.

Цэргийн даргалах бүрэлдэхүүнийг бэлтгэх зорилгоор 1921 оны 8 дугаар сарын 20-нд хорин сурагчийг бүртгэж, улмаар 10 дугаар сарын 15-нд 90 хүнтэйгээр морин

цэрэг, улс төрийн гэсэн хоёр ангитай, зургаан сарын хугацаатай сургалтаа эхлүүлжээ. Анхны захирлаар нь П.М.Толпыгин, комиссараар нь Н.Юмжав нар томилогджээ. Даргын сургуулийн анхны төгсөлт 1921 оны 12 дугаар сарын 25-нд болж, салаан дарга 15, хагас салаан дарга зургааг төгсгөжээ.

Даргын сургуульд 1922 оноос их бууны салаа нэмэн байгуулж, суралцах хугацааг нэг жил болгосон бол 1923 онд Ардын засгийн газар “Даргын сургуулийг шинэчлэн байгуулах тухай дүрэм” баталж, сургуулийн морин анги, их бууны анги, пулемётын ангийн суралцах хугацааг гурван жил болгон суман, салаан дарга нарыг бэлтгэх, мөн морин цэрэг, их бууны дарга нарыг давтан сургах 10 сарын хугацаатай курс байгуулах, суртлын сургагч, холбоочдыг нэг жил, захиргаа, аж ахуйн ажилтнуудыг найман сарын хугацаатай бэлтгэх тогтолцоотой болгосон байна.

1933 оны нэгдүгээр сард БНМАУ-ын СнЗ-ийн тогтоолоор Дотоодыг хамгаалах газарт баруун ба өмнөт хязгаарыг хамгаалах үүрэг өгч, анхны хилийн отряд, комендатуруудыг байгуулснаар орчин үеийн Хил хамгаалах байгууллага үүссэн юм.

Хилийн цэргийн туулж өнгөрүүлсэн дайчин замнал нь Монголын ард түмний тусгаар тогтнолд халдан довтолсон харийнхны өнгөлзлөгийг цаг тухайд нь илрүүлэн зогсоож, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг чанд хамгаалсан мятаршгүй эх оронч хилчдийн тэмцэл, ялалтын түүх юм.

Улс орныг харийн түрэмгийн нараас батлан хамгаалах, улсын хил хязгаарын бүрэн бүтэн байдлыг сахиулах боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн /хуучин нэрээр/ 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор “Дотоодыг хамгаалах газрын дунд сургууль” байгуулах шийдвэр гаргажээ.

Энэхүү түүхэн зурвас үед дэлхийн томоохон гүрнүүд цэрэг-улс төрийн томоохон давалгаануудад өртсөн XX зууны сүүлийн хагаст цэргийн сургалт бэлтгэлд эрс шинэчлэлт хийгдэж эхэлжээ.

Учир нь дэлхийн томоохон гүрнүүд, тэдгээрийг дагалдан талцалд орсон улс орнуудын зэвсэглэлээр хөөцөлдөх, бүс нутгийн хэмжээнд, цаашлаад дэлхийн хэмжээнд нөлөө бүхий байх эрмэлзлэл дээд хэмжээндээ хүрсэн.

Үүнийг дагаад цэргийн зэвсэг, техникийн судалгаа, шинжилгээ, нэгжүүдийн бүтэц, алба хаагчдын гүйцэтгэх үүрэг эрчимтэй шинэчилэгджээ.

Өнгөрөгч 1970 – 1990 оны хооронд төрөл мэргэжлийн цэргийн фронт, армид эзлэх хувь эрчимтэй нэмэгдэв. Цэргийн сургалт, тэр дундаа офицер бэлтгэх сургалт академик түвшинд хүрсэн.

Цэргийн сургалт бэлтгэлийн талаар тухайн үед үндсэн 3 төрлийн арга барил бий болсон. Үүнд:

- Бидний сайн мэдэх “Орос школ” буюу онолын мэдлэгийг танхимаар олгон ажлын талбарт практикт сурган хүмүүжүүлэх, улмаар ажлын арга барил, удирдах авьяаст тулгуурлан мэргэшүүлэх, цаашид

академийн боловсрол эзэмшүүлэн удирдах шатны алба хаагч бэлтгэх тогтолцоо,

- Бундесверийн буюу бага офицер /дэслэгч, ахлах дэслэгч/-ыг сургаж бэлтгэн дипломын боловсрол олгон ажлын талбарт /салааны удирдлага, төрөл мэргэжлийн алба хаагч/ гаргаад дунд офицер болохын тулд дахин сургалтад хамрагдан шалгалт өгч бакалаврын түвшний мэдлэг эзэмшиж байж дараагийн шатны албан тушаалд томилогддог, ахлах офицер болохын тулд академийн түвшний сургалтад хамрагдан стратегийн хэмжээний мэдлэг олгон шалгалт авч шат ахиулдаг тогтолцоо,

- Англи-Америкийн буюу шаардлагатай албан тушаалд нь тохирсон сургалтыг нэгдсэн байдлаар, бодит нөхцөлтэй ойртуулсан нөхцөлд явуулан шалгалт авч тухайн албан тушаалд томилох ба тухайн алба хаагч өөрийн хүсэлтээр дээд шатны албан тушаалд очихын тулд дахин сургалтад хамрагдан шалгуур хангаж байж томилогддог тогтолцоонууд орчин үеийн сургалт бэлтгэлийн үндэс суурь болжээ.

Хоёр.Хилийн цэргийн сургалт бэлтгэлийн зорилго, агуулга

Цэргийн сургалт бэлтгэл нь бидний үндсэн хөдөлмөр бөгөөд өдөр тутамдаа хийж байх ёстой ажил.

Сургалт бэлтгэл хэдий чинээ сайн явагдана тэр хэмжээгээр анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх чадавхи нэмэгдэж байдаг.

Цэргийн сургалт бэлтгэлийг явуулахад нөлөө үзүүлдэг гол гурван зүйл бий. Нэгдүгээрт, сургалтын орчин, нөхцлийг бүрдүүлэх асуудал чухал.

Хоёрдугаарт, сургалтыг тасралтгүй явуулах үндсэн нөхцөл нь материал-техникийн бүрэн хангалт байх ёстой.

Гуравдугаарт, зэвсэглэл, техник дээр аль болох түлхүү ажиллуулж, мэргэжлийн алба хаагчдыг зөв сонгох тухай асуудал юм.

Гурав.Цэргийн сургалтын зарчмууд, түүнийг тактикийн бэлтгэл сургуулийн явцад тусгах нь;

Цэргийн сургалтын зарчим гэдэг нь нийт бүрэлдэхүүнийг бэлтгэх ерөнхий зорилттой уялдсан, сургалтын шинж чанарыг тодорхойлж өгдөг удирдлагын гол заалт мөн.

Түүнд;

Намч зарчим;

Байлдаанд юу шаардагдвал түүнд сургах;

Байлдааны байнгын бэлэн байдлыг хангах;

Суралцагчдыг ухамсартай идэвхтэй болгон сургах;

Үзүүлэн таниулах;

Дэс дараалсан, системтэй сургалт:

Дөхөм хялбараар ойлгуулах;

Мэдлэг, дадлага чадварыг гүн бат эзэмшүүлэх;

Хамт олноор буюу нэг бүрчлэн сургах зэрэг зарчмууд багтдаг.

Цэргийн сургалтын процесс дайчдад гүн мэдлэг, бат тогтвортой, уян хатан дадлагууд өгөх төдийгүй нийт бүрэлдэхүүнд улс төр, ёс суртахууны өндөр чанарыг төлөвжүүлж өгдөг улс төрийн чиглэл нь намч зарчим

зайлшгүй байхыг шаардаж байна. Байлдааны жинхэнэ байдалд ойртуулан сургах, байлдааны байнгын бэлэн байдлыг хангах энэ зарчмууд нь цэргийн сургалтыг гол хөтлөгч зарчим мөн. Эдгээр нь бусад зарчмуудын үндсэн агуулгыг ямар нэг хэмжээгээр тодорхойлж өгдөг учраас тэдгээрийг байлдааны бэлтгэл сургуулийн хөтлөгч зарчим гэж нэрлэдэг.

Сургалтыг дөхөм хялбар болгохын тулд заах материалыг суралцагчдын урьд өмнө эзэмшсэн мэдлэг дадлагатай нь холбож өөрөөр хэлбэл тэдний мэдэх зүйлээс ммэдэхгүйд нь шилжүүлэх замаар хичээлийг явуулах нь чухал.

Сургалтын арга хэлбэрийн тухай
ойлголт;

Сурган хүмүүжүүлэх үүргийг амжилттай шийдвэрлэхийн тулд сургалтын төрөл бүрийн арга, хэлбэрүүдийг зөв ойлгож, түүнийг бүрэн ашиглаж чаддаг байх нь чухал.

Сургалтын арга нь сургаж байгаа хүний сургуульд оролцогсдыг удирдах ажлын арга зам мөн.

Офицер, штаб болон цэрэгтэй явуулах тактикийн бэлтгэл сургуулийн явцад сургалтын дараахь аргуудыг хэрэглэдэг. Үүнд: ярианы арга (тайлбарлах, лекц унших ярилцах, үзүүлэх, дасгал, дадлагын ажил, ном зохиолыг бие даан судлах зэрэг олон аргууд байдаг.

Сургалтын хэлбэр нь юуны өмнө сургуулийг явуулах бүхий л нөхцөл өөрөөр хэлбэл сургуульд оролцох бүрэлдэхүүн, хичээл, сургуулийн зохион байгуулалт,

түүнийг явуулах газар орон болон үргэлжлэх хугацааг тусгасан байдаг.

Офицер, штабууд болон анги, нэгтгэлүүдийг тактикийн бэлтгэлээр сургахад лекц унших, семинар явуулах булгийн дасгал, тактикийн шуурхай дадлага хийх, штабын дадлага, тактик, тактик-жагсаалын сургууль, хээрийн сургууль, байлдааны буудлагатай сургууль, команд штабын цэргийн тоглоом болон бие даасан сургалт зэрэг нилээд дэлгэрсэн нийтлэг аргуудыг хэрэглэдэг. Цэрэгтэй явуулах тактикийн ялангуяа байлдааны буудлагатайгаа явуулах тактикийн хээрийн сургууль бол тактикийн бэлтгэлийн хамгийн дээд хэлбэр мөн.

Сургалтын зарим нэг хэлбэрт зөвхөн ганц арга байж болох бөгөөд тийм байдалтай уялдаж сургалтын зарим нэг хэлбэр нь аргынхаа дагуу нэрлэгддэг явдал бий. Тийм учраас <лекц>> гэдэг хэллэг нь сургалтын арга хэлбэрийн алиныг ч тодорхойлж өгдөг.

Сургалтын олон төрлийн хэлбэр нь нийт бүрэлдэхүүнийг нэг бүрчлэн болоод хамт олноор нь сургах, тэдэнд гүн бат мэдлэг олгож, олон талын чадвар, дадлагатай явуулснаар ёс суртахуун-байлдааны өндөр чанараар хүмүүжүүлэх бүрэн бололцоог олгодог.

Сургалтын арга, хэлбэр нь хоорондоо салшгүй холбоотой байдаг. Хэрэв сургалтын хэлбэр нь сургалтыг хэрэгжүүлэх нөхцөлийн бүрдлийг тусгаж, түүнийг чадсанаар зорилтоо биелүүлэх боломжийг олгодог бол арга нь сургалтаар тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх арга замыг зааж өгдөг.

Сургалтын нэг хэлбэрт хэд хэдэн арга хэрэглэгдэж байгаа бол

түүний нэг нь голлох арга нь болж байх ёстой.

Хэрэв энэ зарчмыг зөрчвөл сургуулийн зорилтыг биелүүлж чадахгүй.

Жишээлбэл: Тактик-жагсаалын сургуулийг явуулахад тактикийн арга, үйлдлийг элемент элементээр нь хийх нийт бүрэлдэхүүний дасгал (дадлага) нь сургалтын голлох арга нь болно.

Штабуудыг бэлтгэх гол хэлбэр нь штабын дадлага команд-штабын цэргийн тоглоомыг зураг дээр, команд-штабын хээрийн сургуулийг газар орон дээр тус тус явуулах болно. Цаашид штабуудын бэлтгэлийг улам дээшлүүлэх арга бол цэрэгтэй явуулах тактикийн хээрийн сургууль мөн.

Тактикийн сургалтанд олон төрлийн арга, хэлбэрүүдийг чадварлагаар хэрэглэхийг зүй ёсоор шаарддаг.

Сургалтын аргын агуулга

- Тайлбарлах арга нь бараг бүх төрлийн хичээл сургуульд их бага хэмжээгээр хэрэглэгддэг. Энэ аргыг ихэвчлэн сургалтын бусад аргуудтай хослуулан хэрэглэнэ. Жишээлбэл, тайлбарлах аргыг дасгал буюу үзүүлэх аргын өмнө дасгал, дадлагын ажлын явц дунд буюу төгсгөлд хэрэглэж болно.

Тайлбарлах арга нь дүрэм зааврын заалтуудыг дэлгэрүүлэн ойлгуулах, захирагдагсдаас материалыг гүнзгий дүгнэлтгүйгээр судлах, тэрчлэн тэднээс тактикийн ямар нэг үзэгдлийг бүтээлчээр судлах хандлагатай болгон хүмүүжүүлэхэд хамгийн түрүүн үйлчилдэг.

- Лекцийн аргыг офицеруудээс онолын холбогдолтой асуудлыг судлах үед ихэвчлэн хэрэглэдэг. Энэ нь үзэж байгаа сэдвийн гол санаануудыг системтэй, дэс дараатайгаар задруулан ярихад бүрэн бололцоог өгдөг. Түүнээс гадна лекц нь сурч байгаа хүмүүсээс цаашид бие даан ажиллах чиглэлийг олж авахад тус болдог.

- Ярианы аргыг сонсогчдын урьд өмнө олж авсан төсөөлөл, ойлголт, хувийнх нь онцлог байдал туршлагад нь тулгуурлан, тэдний мэдлэгийг шалгах, түүний нь өргөжүүлэн системтэй болгох зорилгоор хэрэглэж болно.

- Үзүүлэх сургуулийг, төлөвлөгөөнд орсон хичээлийг удирдан хийгдэхээс өмнө явуулах нь зүйтэй. Ийм сургуулийг дээд тушаалын дарга нар удирдаж явуулдгаараа онцлогтой. Жишээлбэл хорооны тактикийн үзүүлэх сургуулийг армийн командлалаас удирдаж явуулдаг Ийм сургуулийг эртнээс сайн бэлтгэх хэрэгтэй.

Хичээл дээр үзүүлэх материалуудыг ашиглах дэс дараа, ямар тайлбар өгөхөө урьдаас сайн бэлтгэх нь чухал байдаг.

Материалыг бие даан судлахад: гүйлгэж унших, үргэлжлүүлэн унших, судалж унших гурван аргыг хэрэглэдэг. Судалж байгаа сэдвийн онцлог сонгож авсан номын ач холбогдлыг харгалзан энэ гурван аргын аль алиныг хэрэглэж чаддаг байх нь чухал.

Практик ажиллагаа гэдэг нь сонсогчдоос байлдааны цагийн байдалд ойртсон тийм нөхцөлд, тодорхой хугацаанд өөрийн үүрэгт ажлаа хийж гүйцэтгэхийг хэлнэ.

Практик ажиллагаа нь сонсогчдоос тодорхой хэмжээний бэлтгэл, бие даан ажиллах өндөр чадварыг шаарддаг тул суралцагчдаас дадлагын зохих хэмжээний мэдлэг эзэмшсэний дараа энэ ажилд шилжин орно. Тийм ч учраас энэ аргыг команд-штабын болон тактикийн сургуулиар нилээд өргөн хүрээтэй хэрэглэдэг.

ДҮГНЭЛТ

Монгол Улс нь өөрөө цөөн хүн амтай, томоохон газар нутагтай учраас хилчдийг нөхөн хангах хязгаарлагдмал нөөцтэй улс. Дэлхийн жишигт Зэвсэгт хүчнээ бүрдүүлдэг нөхөн хангалтын хэд хэдэн тогтолцоо бий. Манай улсын хувьд бид холимог тогтолцооны аргаар буюу зарим бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар, нөгөө хэсгийг нь сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаалгах замаар нөхөн хангалтыг хийж байна.

Энэ тогтолцоогоор шинээр татагдсан хугацаат цэргийн алба хаагчдийг сургаж бэлтгэх асуудал зөвхөн сургалтын төвөөр хязгаарлагдан, цаашид практикаар дадлага олж авах төдийгөөр хязгаарлаж байгаа нь осол зөрчилд холбогдох, улсын хил хамгаалалтын үр дүн төдийлөн дээшлэхгүй байгаа зэрэг дутагдлын эх үндэс болж байхыг үгүйсгэхгүй.

Бидний цаашдын сургалт бэлтгэлийн зорилт Хил хамгаалах байгууллагын хөгжлийн бодлоготой уялдаж мэргэшсэн хилчин бэлтгэх замаар улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах явдал юм.

Мэргэжлийн хилчин гэдэгт офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчдыг хамруулан ойлгож байгаа

бөгөөд тэднийг мэргэжлийн хувьд нь чадваржуулах, тасаг, салаа, салбараар нь үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх бэлтгэлийг чиглүүлэн явуулахад анхаарах нь зүйтэй.

Хилчдийн сургалт бэлтгэл нь агуулгын хувьд өөрчлөгдөж байна. Учир нь бид хугацаат цэрэг төвтэй сургалтаас байнгын бүрэлдэхүүн төвтэй сургалт руу шилжих шилжилтийн үеийг өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд туулж ирлээ. Одоо мэргэшсэн хилчин бэлтгэх сургалт бэлтгэлд түлхүү анхаарах, тэдгээрийг чадваржуулахад чиглэгдсэн хөтөлбөр агуулгыг улам боловсронгуй болгох, түүнийг анги, салбаруудад хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх нь чухал юм.

Эх сурвалжийн жагсаалт:

-Улсын их хурал, Засгийн газрын тогтоол, бодлогын баримт бичиг:

-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр “Алсын хараа 2050”., 2020

-Хууль тогтоомж:

Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2016

-Ном сурах бичиг, гарын авлага:

- Жавхланцогт.В, Өвгөнбүргэд.Ж нар, Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь. УБ., 2017
- Пүрэвсүрэн.Н, Доржбал.Ш нар, Цэргийн боловсрол судлал. УБ., 2004
- Офицер, штаб, нэгтгэл, ангид тактикийн бэлтгэл заах арга зүй. УБ., 1974

- Мягмаржав.Г, Цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс. УБ.,1999
- Энхжаргал.Ц, Хил хамгаалах байгууллагын офицерын сургалт бэлтгэлийн тогтолцоо, түүнийг сайжруулах арга. УБ., 2020